



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 07 өдөр

Дугаар А/259

Хэрлэн сум

Үхэр сүргийн үүлдэрлэг байдлыг
тодорхойлох, үзлэг ангилалт хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66.1 дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын А/205 тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үхэр сүрэгт үзлэг ангилалт хийж, генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох, ялган тэмдэглэж бүртгэлжүүлэлтэнд хамруулах ажлыг хууль тогтоомжид нийцүүлэн технологийн хугацаанд үр дүнтэй зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.


Ажлын хэсгийн дарга:	Г.Гантөмөр	Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
Нарийн бичиг:	С.Гантулга	Мал аж ахуйн хэлтсийн малын удам зүйн үнэлгээ, үржил селекц хариуцсан ахлах мэргэжилтэн
Гишүүд:	Г.Ариунчимэг	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн бодлого хариуцсан мэргэжилтэн
	Ц.Эрдэнэцэцэг	Мал аж ахуйн хэлтсийн малын генетик нөөцийн бүртгэл, мэдээлэл хариуцсан мэргэжилтэн
	Ц.Алтансолонго	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн

2. Үхэр сүрэгт үзлэг ангилалт хийж, төлөв байдлыг тодорхойлох, ялган тэмдэглэж бүртгэлжүүлэлтэнд хамруулах малын судалгааг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2.

3. Үхэр сүрэгт үзлэг ангилалт хийж, төлөв байдлыг тодорхойлох, ялган тэмдэглэж бүртгэлжүүлэх ажлыг технологит хугацаанд үр дүнтэй зохион байгуулж, стандартын шаардлага хангасан үржлийн малыг ялган тэмдэглэж, малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд хамруулж, 2025 оны 11 дүгээр сарын 10-ны дотор тайлагнахыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Гантөмөрт)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Баярхүү)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д. АЮУРБУНЬ



سليم بن عبد الله

[illegible]



Аймгийн Засаг даргын 2025 оны
05 дугаар сарын 04 -ний өдрийн
А/259 дугаар захирамжийн хавсралт

ҮХЭР СҮРГИЙН ҮҮЛДЭРЛЭГ БАЙДЛЫГ
ТОДОРХОЙЛОХ, ҮЗЛЭГ АНГИЛАЛТ ХИЙЖ ЯЛГАН ТЭМДЭГЛЭХ
БҮРТГЭЛЖҮҮЛЭХ МАЛЫН ХУВААРЬ

№	Сумын нэр	Үүлдэр, омгийн нэр	Хээлтэгч	Хээлтүүлэгч	Нийт
1	Дадал	Дадалын ухаа	7800	200	8000
2	Баян-Адарга	Нутгийн	6500	150	6650
3	Биндэр	Нутгийн	6000	300	6300
4	Норовлин	Нутгийн	5500	350	5850
Бүгд			25800	1000	26800

Тайлбар: ХХААХҮСайдын 2018 оны 04 дүгээр сарын 18-ний өдрийн А/68 тушаалаар батлагдсан “Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний төрөл, жишиг тариф”-аар тооцсон болно